**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Дархан-Уул аймгийн Мал эмнэлгийн газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** ДАА-2024/11/НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Дархан-Уул аймаг<br>2024 он | Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр:<br>Утас: 70378845<br>Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn<br><br>Аудитын менежер:У.Батсүрэн<br>Утас:70373089<br>Цахим хаяг: batsurenu@audit.gov.mn<br><br>Ахлах аудитор: С.Батцэцэг<br>Утас: 70373089<br>Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn<br><br>Ахлах аудитор: Х.Сувдмаа<br>Утас: 70373089<br>Цахим хаяг: suvdmaakh@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт**

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Бэхэлгээний гудамж-1, 14 дугаар баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг 45078
Утас: 7037-3080, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2024.02.21 № 23

танай ______________ -ны № ______________ -т

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН МАЛ ЭМНЭЛГИЙН
ГАЗРЫН ДАРГА Б.НЯМДОРЖ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Мал эмнэлгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дархан-Уул аймгийн Мал эмнэлгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тус газар нь "Амьтны эрүүл мэндийн лаборатори"-оос тандалтын зардал 6,453.6 мянга, ХХААХҮЯ-ны даргын 2023 оны А/125, А/209 тоот тушаалаар малын шүлхий өвчний эсрэг үйлчилгээний хөлс 165,290.6 мянга, аймгийн Засаг даргын 01-А/41 тоот захирамжаар орон нутгийн хөгжлийн сангаас 124,159.9 мянга, Засаг даргын нөөц хөрөнгөөс 89,259.0 мянган төгрөгийн эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгслийг төлбөргүйгээр авч зориулалтын дагуу зарцуулан санхүүгийн тайланд үнэн зөв бүртгэсэн байна.

**Аудитын гол асуудал**

Монгол Улсын Засгийн Газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор төрийн албан хаагчдын цалин хөлсийг шинэчлэн тогтоосон, мөн Засгийн газрын 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 272 дугаар тогтоолоор орон нутгийн нэмэгдлийг тооцох олгосон. Мөн Засгийн газрын 2023 оны 52 дугаар тэмдэглэлээр цалингийн сангийн хэмнэлтээс ажилтны ажлын үр дүнг нь харгалзан үндсэн цалингийн 80-100 хувиар урамшуулал олгожээ.

**Бусад асуудлын хэсэг**

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Дархан-Уул аймгийн Мал эмнэлгийн газар нь 2023 оны 4 дүгээр улирлын байдлаар гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын 13 арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлснийг Засаг дарга 99.15 хувиар үнэлж, "Хангалттай" гэж дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд өгөх бидний дүгнэлт бусад мэдээллийг хамрахгүй болно.

009020039

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшний боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд, АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийллийг бүрэн илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэх болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ш.МӨНХБАЯР

## Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **78,892,299.29** | **166,915,896.94** |
| **34** | **УРЬДЧИЛГАА** | **-** | **-** |
| 34600 | Урьдчилж гарсан зардал | | |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **78,892,299.29** | **166,915,896.94** |
| **351** | **Түүхий эд материал** | **61,098,344.89** | **132,919,300.54** |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 18,105,869.00 | 16,463,537.70 |
| 35130 | Эм боох материал | 42,992,475.89 | 116,455,762.84 |
| **354** | **Хангамжийн материал** | **17,793,954.40** | **33,996,596.40** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 780,630.00 | 1,955,680.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 12,878,892.00 | 15,459,484.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 835,200.00 | 3,162,200.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 3,299,232.40 | 13,419,232.40 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **111,360,038.60** | **279,256,912.69** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **111,360,038.60** | **279,256,912.69** |
| **392** | **Биет хөрөнгө** | **110,360,038.67** | **278,712,912.76** |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 72,602,790.84 | 178,485,790.84 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (35,667,790.73) | (31,332,397.49) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 180,767,845.55 | 194,227,028.68 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (123,317,609.30) | (75,972,604.36) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 24,873,670.00 | 24,798,290.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (8,898,867.69) | (11,493,194.91) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | **999,999.93** | **543,999.93** |
| 39301 | Программ хангамж | 2,280,000.00 | 2,280,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (1,280,000.07) | (1,736,000.07) |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **190,252,337.89** | **446,172,809.63** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **9,794,650.00** | **-** |
| 41 | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **9,794,650.00** | **-** |
| 41300 | Өглөг | **9,794,650.00** | **-** |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 9,794,650.00 | |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **-** | **-** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | | |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 180,457,687.89 | 446,172,809.63 |
| 51101 | Өмч: - төрийн | 180,457,687.89 | 446,172,809.63 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | **180,457,687.89** | **446,172,809.63** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 281,745,995.96 | 180,457,687.89 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | (101,288,308.07) | 265,715,121.74 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **190,252,337.89** | **446,172,809.63** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **733,886,392.76** | **1,501,550,418.52** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **188,519,422.76** | **450,867,210.83** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 188,519,422.76 | 450,867,210.83 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 188,519,422.76 | 450,867,210.83 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 3,941,800.00 | 7,733,821.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө | 4,029,519.00 | 189,298,728.86 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал | 180,548,103.76 | 253,834,660.97 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **545,366,970.00** | **1,050,683,207.69** |
| **1310** | **Улсын төсвөөс** | **363,134,900.00** | **643,879,900.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 363,134,900.00 | 643,879,900.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **182,232,070.00** | **406,803,307.69** |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 115,727,200.00 | 213,073,067.69 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 66,504,870.00 | 193,730,240.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **835,174,700.84** | **1,235,835,296.77** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **835,174,700.84** | **1,235,835,296.77** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **816,127,455.84** | 1,098,517,954.77 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **226,102,748.00** | **405,550,523.31** |
| 210101 | Үндсэн цалин | 163,245,927.60 | 260,685,754.00 |
| 210102 | Нэмэгдэл | 37,397,823.00 | 107,702,290.31 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 15,812,499.40 | 18,343,500.00 |
| 210104 | Урамшуулал | 9,646,498.00 | 18,818,979.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **28,900,898.00** | **51,740,263.38** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 19,781,132.80 | 35,274,326.34 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,327,191.23 | 4,149,920.70 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,811,352.91 | 3,284,736.54 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 452,838.32 | 819,424.16 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,528,382.74 | 8,211,855.64 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **1,500,000.00** | **4,970,000.00** |
| 210304 | Байрны түрээс | 1,500,000.00 | 4,970,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **41,049,721.34** | **27,006,078.85** |
| 210401 | Бичиг хэрэг | 1,243,800.00 | 2,392,050.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 10,432,720.00 | 16,610,640.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,528,600.00 | 1,712,700.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 300,000.00 | 240,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,177,741.00 | 2,445,668.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | | 2,131,731.30 |

| | | | |
|---|---|---|---|
| 210409 | Бараа материал шилжүүлсний зардал | 24,366,860.34 | 1,473,289.55 |
| **2105** | **Нормативт зардал** | **208,516,736.89** | **258,904,674.46** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 208,245,936.89 | 258,904,674.46 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 270,800.00 | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **1,907,000.00** | **7,198,400.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 659,200.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 1,247,800.00 | 7,198,400.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **4,627,000.00** | **11,360,100.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 4,627,000.00 | 11,360,100.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **219,671,100.00** | **284,267,260.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 210,304,030.00 | 276,338,050.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,000,000.00 | 2,490,100.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 407,070.00 | 347,110.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 121,000.00 | 187,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 7,839,000.00 | 4,905,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **83,852,251.61** | **47,520,654.77** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 10,015,770.20 | |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | | 720,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 73,836,481.41 | 46,800,654.77 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **19,047,245.00** | **137,317,342.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **300,000.00** | **59,198,331.00** |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | | 58,998,331.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 300,000.00 | 200,000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 18,747,245.00 | 78,119,011.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 18,747,245.00 | 78,119,011.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(101,288,308.08)** | **265,715,121.75** |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | | |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(101,288,308.08)** | **265,715,121.75** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **549,308,770.00** | **1,058,417,028.69** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **3,941,800.00** | **7,733,821.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 3,941,800.00 | 7,733,821.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 3,941,800.00 | 7,733,821.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 3,941,800.00 | 7,733,821.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **545,366,970.00** | **1,050,683,207.69** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 363,134,900.00 | 643,879,900.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 363,134,900.00 | 643,879,900.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **182,232,070.00** | **406,803,307.69** |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 115,727,200.00 | 213,073,067.69 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 66,504,870.00 | 193,730,240.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **549,308,770.00** | **1,033,018,228.69** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **549,308,770.00** | **1,033,018,228.69** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **530,261,525.00** | **895,700,886.69** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **226,136,387.00** | **405,550,523.31** |
| 210101 | Үндсэн цалин | 163,279,566.60 | 260,685,754.00 |
| 210102 | Нэмэгдэл | 37,397,823.00 | 107,702,290.31 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 15,812,499.40 | 18,343,500.00 |
| 210104 | Урамшуулал | 9,646,498.00 | 18,818,979.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **28,900,898.00** | **51,740,263.38** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 19,781,132.80 | 35,274,326.34 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,327,191.23 | 4,149,920.70 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,811,352.91 | 3,284,736.54 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 452,838.32 | 819,424.16 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,528,382.74 | 8,211,855.64 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **1,500,000.00** | **4,970,000.00** |
| 210304 | Байрны түрээс | 1,500,000.00 | 4,970,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **13,796,720.00** | **26,370,840.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 940,700.00 | 2,777,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 9,614,320.00 | 18,448,640.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,528,600.00 | 1,712,700.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 300,000.00 | 240,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,413,100.00 | 3,192,500.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **49,310,670.00** | **91,487,900.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 48,848,070.00 | 90,917,800.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 462,600.00 | 570,100.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **3,313,400.00** | **8,990,300.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1,449,200.00 | 1,311,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,864,200.00 | 7,678,800.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **4,627,000.00** | **11,360,100.00** |

| | | | |
|---|---|---|---|
| 210702 | Дотоод албан томилолт | 4,627,000.00 | 11,360,100.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **202,676,450.00** | **294,510,960.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 200,509,380.00 | 286,581,750.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | | |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,000,000.00 | 2,490,100.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 407,070.00 | 347,110.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 121,000.00 | 187,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 639,000.00 | 4,905,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **-** | **720,000.00** |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | - | 720,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **19,047,245.00** | **137,317,342.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **300,000.00** | **59,198,331.00** |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | | 58,998,331.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 300,000.00 | 200,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **18,617,445.00** | **78,119,011.00** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 18,617,445.00 | 78,119,011.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 129,800.00 | - |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 129,800.00 | |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **-** | **25,398,800.00** |
| | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **-** | **-** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **-** | **25,398,800.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **-** | **25,398,800.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | - | 25,398,800.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | | 25,398,800.00 |
| **2260** | **Гадаад эх үүсвэрээр** | - | - |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-** | **(25,398,800.00)** |
| | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **-** | **-** |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **-** | **-** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **-** | **-** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **-** | **-** |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **-** | **-** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | | |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **-** | **-** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | - | - |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | |

## 2.4 Өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл** | | | **281,745,995.96** | | **281,745,995.96** |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | | |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | | | **281,745,995.96** | | **281,745,995.96** |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | | | - | | **-** |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | | | - | | **-** |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | - | | **-** |
| C07 | Тайлант үеийн үр дүн | | | (101,288,308.07) | | (101,288,308.07) |
| C08 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | | | **108,457,687.89** | | **108,457,687.89** |
| D01 | **2023 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл** | | | **108,457,687.89** | | **108,457,687.89** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | - | | - |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | | | **108,457,687.89** | | **108,457,687.89** |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | | | - | | - |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | | | - | | - |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | - | | - |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | | - | | - |
| D08 | Тайлант үеийн үр дүн | | | 265,715,121.74 | | 265,715,121.74 |
| D09 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | | | **446,172,809.63** | | **446,172,809.63** |

## 2.5 Төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **647,379,900.00** | **573,494,710.00** | **(73,885,190.00)** | 88.59 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **647,379,900.00** | **573,494,710.00** | **(73,885,190.00)** | 88.59 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **588,060,000.00** | **514,296,379.00** | **(73,763,621.00)** | 87.46 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **443,684,600.00** | **377,921,930.00** | **(65,762,670.00)** | 85.18 |
| 210101 | Үндсэн цалин | 266,094,400.00 | 255,796,874.00 | (10,297,526.00) | 96.13 |
| 210102 | Нэмэгдэл | 114,336,900.00 | 84,962,577.00 | (29,374,323.00) | 74.31 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 21,991,000.00 | 18,343,500.00 | (3,647,500.00) | 83.41 |
| 210104 | Урамшуулал | 41,262,300.00 | 18,818,979.00 | (22,443,321.00) | 45.61 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **55,460,200.00** | **48,286,689.00** | **(7,173,511.00)** | 87.07 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 37,712,900.00 | 32,925,895.79 | (4,787,004.21) | 87.31 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,436,800.00 | 3,873,634.75 | (563,165.25) | 87.31 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,549,400.00 | 3,063,707.80 | (485,692.20) | 86.32 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 887,300.00 | 764,166.95 | (123,133.05) | 86.12 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,873,800.00 | 7,659,283.71 | (1,214,516.29) | 86.31 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **4,970,300.00** | **4,970,000.00** | **(300.00)** | 99.99 |
| 210304 | Байрны түрээс | 4,970,300.00 | 4,970,000.00 | (300.00) | 99.99 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **19,524,200.00** | **19,464,200.00** | **(60,000.00)** | 99.69 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,777,000.00 | 2,777,000.00 | - | 100.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 11,542,000.00 | 11,542,000.00 | - | 100.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,712,700.00 | 1,712,700.00 | - | 100.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 300,000.00 | 240,000.00 | (60,000.00) | 80.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,192,500.00 | 3,192,500.00 | - | 100.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **951,600.00** | **950,000.00** | **(1,600.00)** | 99.83 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 379,900.00 | 379,900.00 | - | 100.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 571,700.00 | 570,100.00 | (1,600.00) | 99.72 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **24,389,100.00** | **24,389,100.00** | **-** | 100.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 16,710,300.00 | 16,710,300.00 | - | 100.00 |
| 210604 | Урсгал засвар | 7,678,800.00 | 7,678,800.00 | - | 100.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **4,245,000.00** | **3,960,100.00** | **(284,900.00)** | 93.29 |
| 210702 | Дотоод албан томилолт | 4,245,000.00 | 3,960,100.00 | (284,900.00) | 93.29 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **34,115,000.00** | **33,634,360.00** | **(480,640.00)** | 98.59 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 25,729,700.00 | 25,705,150.00 | (24,550.00) | 99.90 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 2,490,100.00 | 2,490,100.00 | - | 100.00 |
| 210804 | Тээврийн хэрэглийн татвар | 703,500.00 | 347,110.00 | (356,390.00) | 49.34 |
| 210805 | Тээврийн хэрэглийн оношилгоо | 187,000.00 | 187,000.00 | - | 100.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 5,004,700.00 | 4,905,000.00 | (99,700.00) | 98.01 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **720,000.00** | **720,000.00** | | 100.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 720,000.00 | 720,000.00 | | 100.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **59,319,900.00** | **59,198,331.00** | **(121,569.00)** | 99.80 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **59,319,900.00** | **59,198,331.00** | (121,569.00) | 99.80 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 58,998,400.00 | 58,998,331.00 | | 100.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 321,500.00 | 200,000.00 | (121,500.00) | 62.21 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **647,379,900.00** | **573,494,710.00** | (69,651,369.00) | 88.59 |
| | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **643,879,900.00** | **565,760,889.00** | **(73,885,190.00)** | 87.87 |
| 131001 | Улсын төсвөөс | 643,879,900.00 | 569,994,710.00 | **(73,885,190.00)** | 87.87 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **3,500,000.00** | **7,733,821.00** | **4,233,821.00** | 220.97 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 3,500,000.00 | 7,733,821.00 | 4,233,821.00 | 220.97 |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | **23** | **19** | **(4)** | 82.61 |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 1 | 1 | - | 100.00 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1 | 1 | - | 100.00 |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | **23** | **19** | **(4)** | 82.61 |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 | - | 100.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 15 | 11 | (4) | 73.33 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 7 | 7 | - | 100.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/Төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Тайлан он |
|---|---|---|
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **407,554,972.31** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **407,554,972.31** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **407,179,140.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **27,962,657.00** |
| 210101 | Үндсэн цалин | 4,888,880.00 |
| 210102 | Нэмэгдэл | 23,073,777.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **3,495,343.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 2,376,840.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 279,625.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 223,701.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 55,925.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 559,252.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **6,906,640.00** |
| 210402 | Тээвэр, шатахуун | 6,906,640.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **90,537,900.00** |
| 210501 | Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 90,537,900.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **10,000,000.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 10,000,000.00 |
| **2107** | **Томилолт зочны зардал** | **7,400,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 7,400,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж** | **260,876,600.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 260,876,600.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 375,832.31 |
| **13** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **407,554,972.31** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **407,554,972.31** |
| 131103 | ЗГНХ, ЗД-ын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс зохих байгууллагын шийдвэрийн дагуу тухай төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 213,824,732.31 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 193,730,240.00 |

## Гурав. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайлан, төсвийн зарцуулалт холбоотой нийт 5,999.0 мянган төгрөгийн зөрчил[1] илэрсэнд зөвлөмж өглөө.

**5.1 Төлбөрийн акт**

Төлбөрийн акт тогтоох зөрчилтэй асуудал гараагүй болно.

**5.2 Албан шаардлага**

Албан шаардлага хүргүүлэх зөрчилтэй асуудал гараагүй болно.

**5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

*1. Төрийн хэмнэлтийн тухай хуультай холбоотой асуудал*

*1.1 Илрүүлэлт:*

Тайлант онд 5,999.0 мянган төгрөгийн зөөврийн компьютер худалдан авахдаа цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээнээс худалдаж аваагүй нь Төрийн хэмнэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д “Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно” гэж заасантай нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж:*

Төрийн хэмнэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д заасны дагуу цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахгүй байх

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5[2]-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймгийн Төрийн аудитын газарт 2024 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

[2] Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ